



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/455

Арвайхээр

Үзэсгэлэн худалдаа зохион
байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” 03/04 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өвөрхангай түншлэл-2021” үзэсгэлэн худалдааг 2021 оны 9 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Өвөрхангай түншлэл-2021” үзэсгэлэн худалдааг сайтар зохион байгуулж, гарсан үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (И.Доржсүрэн)-т даалгасугай.

3. Хавсралтад тусгагдсан 9,456,000 (есөн сая дөрвөн зуун тавин зургаан мянга) төгрөгийг “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” зорилтот жилийн ажлын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

011100965

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны 09
дугаар сарын 03-ны өдрийн 4155 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Б.Ууганбаяр (Өвөрхангай аймаг дахь Худалдаа аж
үйлдвэрийн танхимын дарга)

Гишүүд: Н.Дулам (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн)

С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө
аж ахуйн газрын дарга)

С.Дуламсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн
хяналтын газрын дарга)

Г.Мөнхтөр (аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт, хэмжил
зүйн хэлтсийн дарга)

Б.Ганбат (Арвайхээр сумын Засаг дарга)

Ц.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн
газрын албаны дарга)

Д.Алтанцэцэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн
газрын мэргэжилтэн)

Д.Тэгшбаяр (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн
газрын мэргэжилтэн)

-оОо-

